



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/15

Батноров сум

┌ Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан ┐
шалгах комисс байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2.3.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын бүрдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга	Сургалтын менежер
Нарийн бичгийн дарга	Архив, бичиг хэргийн ажилтан
Гишүүд	Нярав, аж ахуйн ажилтан
	Нийгмийн ажилтан
	Бага ангийн заах аргын нэгдлийн ахлагч

2.Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дуссан хэргүүдийг архивт шилжүүлэхэд бэлтгэх явцад хяналт тавих, байнгын хадгалалтад баримт сонгох болон холбогдох төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг чиг үүргүүдийг чанартай хэрэгжүүлж ажиллахыг комисст даалгасугай.

3.Комиссын үйл ажиллагааг цаг тухайд нь баримтжуулж, холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулсан ажлын тайланг цаг тухай бүрт нь тайлагнаж байхыг комиссын даргад үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2019 оны 03 дугаар с арын 12-ны өдрийн А/09 дугаартай захирлын тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

ЗАХИРАЛ



Г. ЦЭЦЭГСҮРЭН

Document (D- тушаал)

232501093